



## УЛС ТӨР

БАЙНГЫН ХОРОО

## С.Даваасүрэн: САНХҮҮГИЙН ЗАХ ЗЭЭЛИЙН ТОГЛОГЧДЫН ТОО ӨНДӨР ХӨГЖИЛТЭЙ ОРНЫ ТӨВШНӨӨС ДАВСАН

Ж.ОТГОН

УИХ-ын гишүүд төсөв батлагдсанаас хойш ажилдаа ирэхгүй байнгын хороо, чуулган хуралдах гэж ирц бүрдэхгүй цаг алддаг “мода” дэлгэрлээ. Тухайлбал, өчигдөр УИХ-ын Эдийн засгийн байнгын хорооны хуралдаанд оролцож байгаа гишүүдийн ирц 50 хувьд хүрэхгүй болж, хурлын үйл ажиллагаа хэсэг хугацаанд тасалдаа давлаа. Улмаар байнгын хорооны даргад хандан “УИХ-ын гишүүн Д.Сумъяабазар ирж явна, карт хийгээд ирцэнд оруулчих гэж хэллээ” гээд картыг нь хийснээр хурал хэвийн үргэлжилсэн юм. Эдийн засгийн байнгын хорооны хуралдаанаар Эдийн засгийн хүндрэлийг даван туулах, тогтворжуулах хөтөлбөр батлах тухай УИХ-ын тогтоолын төслийн анхны хэлэлцүүлгийг хийж, ажлын хэсгээс оруулж ирсэн зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хураалган, чуулганы нэгдсэн хуралдаанд оруулахаар болж, шийдвэрлэлээ. Санал хураах шатанд Хөшигийн хөндийд баригдаж буй олон улсын нисэх онгоцны буудлыг даган бий болох хотын ерөнхий төлөвлөлтийг боловсруулж, хэрэгжүүлж эхлэх, Төрийн албаны шинэтгэлийн хүрээнд цомхон чадварлаг байх бүтцийг бүрдүүлэх зэрэг ажлын хэсгээс гаргасан саналууд дэмжлэг хүлээлээ. Мөн УИХ-ын гишүүн Я.Содбаатар, Г.Занданшатар нар тогтоолын төслийн хавсралтын хүрэх үр дүнг Моодсын зээлийн зэрэглэлийг хоёр төвшнөөр ахуулж, олон улсын байгууллагуудаас гаргадаг эзэлжих зэрэглэл, хөрөнгө



Гэрэл зурагч Г.АРГУУЖИН

орүүлалт татах индекс, бизнес эрхлэх чадварын индекс, өрсөлдөх чадварын индексийг сайжруулах гэсэн санал, УИХ-ын гишүүн Ж.Бат-Эрдэнийн Атрын гуравдугаар аяныг үргэлжлүүлж, хэрэгжүүлэх гэсэн санал гишүүдээс тус бүр дэжлэг хүлээлээ. Харин УИХ-ын гишүүн Х.Болорчулууны Эдийн засгийн хүндрэлийг даван туулах хөтөлбөрт багтсан Гачууртын орд төслийг эдийн засгийн эргэлтэд оруулахыг унагаа гэсэн санал нь гишүүдээс олонхийн дэмжлэг хүлээлгүй унасан юм. Гишүүдийн зүгээс нийт 37 горимын санал гаргажээ. Үүнээс уг хөтөлбөрийн нэрийг өөрчилж, эдийн засгийг сэргээх хөтөлбөр болгох санал дэмжигдлээ. Мөн уг хөтөлбөрийг жидц хоёр удаа тайлагнаж байхаар болгов.

Үүний дараа “Монголын хөрөнгийн зах зээлийн байдал, цаашдын чиг хандлага” сэдвээр Санхүүгийн зохицуулах хорооны даргын мэдээлэл сонслоо. Санхүүгийн зах зээлийн хорооноос хийсэн мэдээллээр үнэт цаасны зах зээлд Засгийн газрын үнэт цаас 94 хувийг эзэлж байна. Монгол Улсад хөрөнгийн зах зээл анх өмч хувьчлалтай холбоотойгоор үүсэн байгуулагдсан, гэвч одоог хүртэл сонгодог утгаараа хөгжиж чадахгүй байна. Банк бус санхүүгийн байгууллагын тоо 509-д хүрсэн ч ажлын байр бий болгох талд учир дутагдалтай төдийгүй чанаргүй зээлийн хэмжээ өнгөрсөн жилийнхээс огцом өсчээ. Иймээс эрсдлийг бууруулах зорилгоор банк бус санхүүгийн байгууллагын дүрмийн санг 2.5 тэрбум төгрөгөөр тогтоож өгсөн аж. Харин хадгаламж зээлийн хоршоод 276-д хүрсэн, хөрөнгө нь 108 тэрбумд хүрчээ. Даатгалын компаниудын хувьд хөгжиж буй орнуудаас зургаа дахин бага байна. Мэдээлэлтэй холбогдуулж УИХ-ын гишүүн Д.Дамба-Очир

“Яагаад 800 саяар дүрмийн сан байгуулаад банк бус санхүүгийн байгууллага ажиллуулж болохгүй байна вэ. Яагаад 2.5 тэрбум болгож нэмэгдүүлэх болов. Судалгаанд үндэслэж хийсэн үү. Ард түмний амьдралыг мэдэж хийж чадсан юм уу. Эрдэнэтэд 10 архны үйлдвэр байсан, нэг үйлдвэрт зөвхөн 200 хүн ажилладаг байсан. Гэтэл татварыг нь 100 сая болгосноос нэг нь ч ажиллах боломжгүй болгосон. Энэ бол хэдхэн том банк бус санхүүгийн байгууллагад л боломж олгоод байна” гэдгийг тодруулсан юм. Харин Санхүүгийн зохицуулах хорооны дарга С.Даваасүрэн “Дүрмийн санг нэмэгдүүлэх шийдвэр гаргахдаа тоцоо, судалгааг хийсэн. Эрсдлийн шинжилгээнээс эхлээд бүгдийг хийж үзсэн үндсэн дээр гаргасан. Өрхийн орлого буурч байгаа. Төлбөрийн чадвар муудаж байгаа үүнийг дагаад чанаргүй зээлийн хувь хэмжээ ихсэж байгаа. Олгосон зээлийнх нь тавны нэг нь чанаргүй зээл болж хувирч байна. Дүрмийн санг 2.5 тэрбум болгоход мөн ажлын байр бий болох нь илүү, 5-6 хун ажлын байртай болно. Өрсөлдөх чадвар сайжирна” гэлээ. Үүний хариуд УИХ-ын гишүүн Д.Дамба-Очир “2.5 тэрбумаар хэн ч банк бус санхүүгийн байгууллага байгуулж чадахгүй, юу гэж нэг хүн банк бус санхүүгийн байгууллага ажиллуулах юм. Битгий худлаа яриад бай. Нягтлангаас эхлээд хэд, хэдэн хүн ажилладаг. Дүрмийн санг нэмэгдүүлсэн ажлын байр нэмэгдэнэ гэдэг бол бодитой тайлбар биш. Бодитой зээл гарахгүй байна, энийг л ярьж байна шүү дээ. Шийдвэрээ эргэж харах юм уу” гэв. Санхүүгийн зохицуулах хорооны дарга С.Даваасүрэн “Санал нэг байна, гэхдээ санхүүгийн зах зээл дээр тоглож байгаа тоглогчдын тоо хангалттай хэмжээнд хүрсэн, өндөр хөгжилтэй орны төвшнөөс давсан. Гол нь эрсдэл өндөр

болсон учраас санхүүгийн зах зээлийг хамгаалах зорилгоор авсан арга хэмжээ юм” хэмээн тайлбарлав.

Уг асуудлын дараа тус байнгын хороогоор Төрийн банкны үйл ажиллагаа, хувьчлах бэлтгэл ажлын явц, байдлын талаархи мэдээлэл сонсох юм. Дугаар шилжих мөчид Төрийн банкны асуудлыг хэлэлцэж эхлээгүй байсан юм.

## Монгол нэг ч улстай эдийн засгийн түншлэлийн хэлэлцээр хийж байгаагүй гэв

УИХ-ын Төсвийн байнгын хорооны хуралдаанаар Засгийн газраас УИХ-д өргөн мэдүүлсэн Гаалийн тариф, гаалийн татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн хэлэлцэх эсэхийг хэлэлцсэн юм. Төсвийн байнгын хорооны дарга Ч.Хүрэлбаатар гадаадад албан томилолттой байгаа тул УИХ-ын гишүүн Д.Тогтохсүрэн хуралдааныг даргасан юм.

Монгол Улс Дэлхийн худалдааны байгууллагын олон талт худалдааны хэлэлцээрийн “Тарал үүслийн дүрмийн тухай хэлэлцээр”-г 1994 онд нэгдэн, улмаар 1997 онд Дэлхийн худалдааны байгууллагын “Тариф худалдааны ерөнхий хэлэлцээр”-г гишүүнээр элсэж орсон байна. Засгийн газрын 2016 оны есдүгээр сарын 14-ний өдрийн 46 дугаар хуралдаанаас 2017 оны нэгдүгээр сарын 01-ний өдрийг хүртэл хойшлуулан, Дэлхийн худалдааны байгууллагын тариф, худалдааны ерөнхий хэлэлцээрт гаалийн тариф, гаалийн татварын тухай хуулийг нийцүүлэн нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл боловсруулах талаар чиглэл өгсөн юм байна. Энэхүү хуулийн төсөлд хөнгөлөлттэй тариф хэрэглэх улсын жагсаалтад

орсон боловч Монгол Улсын олон улсын гэрээ, эсвэл нотлох баримт бичиггүй бараанд нэн тааламжтай тариф хэрэглэх, барааны гарал үүслийг нотлох баримт бичигтэй холбоотой зохицуулалт болон барааны гарал үүслийн гэрчилгээ заавал шаардагдах барааны жагсаалтыг Засгийн газар батлах зохицуулалтыг тус тус нэмж тусгаж өгчээ.

Уг хуулийн төсөл нь Монгол Улсын нэгдэн орсон олон улсын хэлэлцээр, Гаалийн хууль болон бусад хуультай нийцэж байгаа бөгөөд улсын төсөвт ямар нэг хүндрэл үзүүлэхгүй гэдгийг Байнгын хорооны хуралдаанд төсөл санаачлагчийн илтгэлийг танилцуулсан Гадаад харилцааны сайд Ц.Мөнх-Оргил онцоллоо. Хэлэлцүүлгийн шатанд, УИХ-ын гишүүн Х.Баделхан “Олон жилийн өмнө Дэлхийн худалдааны байгууллагын гишүүн болчихоод өнөөдөр хуулийн төсөлд нэмэлт өөрчлөлт оруулах, шаардлагатай байгаа юм уу. Хөнгөлөлттэй тарифын жагсаалтад хэчнээн орон багтаж, ямар хөнгөлөлт эдэлж байна вэ” хэмээн тодруулсан. Харин Гадаад харилцааны сайд Ц.Мөнх-Оргил “Монгол Улс Япон улсын хооронд эдийн засгийн түншлэл, чөлөөт худалдааны хэлэлцээр байгуулсан. Хэлэлцээр байгуулсан болохоор Дэлхийн худалдааны байгууллагын гишүүн орнуудын баримталдаг хөнгөлөлтийн тарифыг мөрдөх ёстой. Монгол Улс өмнө нь нэг ч улстай эдийн засгийн түншлэлийн хэлэлцээр хийж байгаагүй болохоор холбогдох хуульд нэмэлт өөрчлөлт оруулах шаардлагагүй байсан юм. Өнөөдөр Япон улстай эдийн засгийн түншлэлийн хэлэлцээр байгуулсан учраас хөнгөлөлтийн тарифыг мөрдөж болгохгүй бол тус улсаас оруулж ирж байгаа худалдаанд 10 хувийн татвар ногдох асуудал үүсээд байгаа. Тиймээс энэхүү хуулийн төслийг өргөн барьж, худалдааны

татварыг тэглэх буюу эсвэл таван хувь болгох шаардлагатай байна” гэсэн хариултыг өгсөн юм. Уг хуулийн төслийн талаар уг хэлэх, саналтай гишүүн байгаагүй учир Гаалийн тариф, гаалийн татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн хэлэлцэх нь зүйтэй гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулахад хуралдаанд оролцсон гишүүд 100 хувь дэмжлээ.

## С.Бямбацогт: Хуулийн төслүүдийг давхардалгүй, уялдаа холбоотой боловсруулах нь чухал

Хуульзүйн байнгын хорооны хуралдаанаар Монгол Улсын хууль тогтоомжийг 2020 он хүртэл боловсруулж болгох үндсэн чиглэлийн төслийг хэлэлцлээ. Энэхүү үндсэн чиглэл батлагдснаар Засгийн газраас 2016-2020 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны хөтөлбөрт тусгасан зорилтыг биелүүлэх, хууль санаачлагчдаас санаачлах хууль тогтоомжийн төслүүд давхардалгүй, тодорхой цаг хугацаанд төлөвлөгдөн, өөр хоорондоо уялдаа холбоотой боловсруулагдах боломжтой болохыг Хууль зүй, дотоод хэргийн сайд С.Бямбацогт хурлын эхэнд онцолсон юм. Хэлэлцүүлгийн үеэр УИХ-ын гишүүд дараах асуудалд харилцар авч, санал хэлсэн юм. УИХ-ын гишүүн Н.Учрал “Өнөөдөр хэрэгжлэж байгаа 600 гаруй хуулиас хөрсөн дээр буугаад хэрэгжиж байгаа нь нэг ч алга. Олон хууль бие биенээ үгүйсгээд байна. Үндсэн хуулийн өөрчлөлт оруулах хэрэгтэй байна гэв. Харин УИХ-ын гишүүн Ж.Энхбаяр “Үндсэн хуулийн өөрчлөлтийг 2017 оны үндсэн чиглэлд оруулаад хэлэлцэх нь зүйтэй. Ерөнхийлөгчийн сонгуультай холбоотойгоор бүх ард түмнээсээ асууж байгаад өөрчлөх хэрэгтэй. Төрийн албаны тухай хуулийг ч мөн өөрчлөх шаардлагатай байна. Хөгжлийн банктай холбоотой 160 тогтоол гарсан байна. Засгийн газар нь хууль зөрчдөггүй болоход мөн анхаарах хэрэгтэй” гэлээ. Энэ үеэр УИХ-ын гишүүн Ж.Батзандан “Улс орон дампуурч байна. Энэ үед Үндсэн хуулинд өөрчлөлт оруулах асуудлыг ард түмнээрээ шийдүүлээд ер нь өөрчлөлт оруулаад явах хэрэгтэй. С.Бямбацогт сайдаа, зоригтой, тууштайгаар хямралыг давах оншгой арга хэмжээ авч, Үндсэн хуулийг өөрчлөх хэрэгтэй” хэмээв. Ингээд гишүүдийн олонхийн саналаар буюу 84.6 хувийн саналаар тус төслийг дэмжиж УИХ-ын чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлэхээр болсон юм.

## МЭДЭЭЛЭЛ

## УИХ-ын дарга шатарчин хүүхдүүдтэй уулзлаа

ОХУ-ын Сочи хотноо энэ оны арванхоёрдугаар сарын 02-12-нд болох Дэлхийн сурагчдын надын аварга шалгаруулах тэмцээнд Монгол Улсаа төлөөлж оролцох өсвөрийн шатарчдыг УИХ-ын дарга М.Энхболд хүлээн авч уулзлаа. Энэ удаагийн тэмцээнд дэлхийн 35 орны 520 гаруй сурагч оролцох юм байна. Манай улсаас 2016 оны Азийн аварга, Дэлхийн шатрын холбооны дэд мастер Лхагважамцын Очирбат, 2016 оны Азийн аварга Мөнхдэмбэрэлийн

Пагамдулам, 2016 оны Ази тивийн сурагчдын аварга шалгаруулах тэмцээний хүрэл медальт, Дэлхийн шатрын холбооны дэд мастер Наранболдын Содбилэгт, Зүүн өмнөд Азийн өсвөрийн шатарчдын аварга шалгаруулах тэмцээний мөнгө, хүрэл медальт, өсвөрийн шатарчдын улсын аварга шалгаруулах тэмцээний мөнгөн медальт Нямдавагийн Энхболор, 2016 оны сурагчдын улсын аварга шалгаруулах тэмцээний алтан медальт Баттулгын Тэнүүнболд

нарын зэрэг 22 хүүхэд оролцох аж. Уулзалтад Монголын шатрын холбооны гүйцэтгэх захирал Б.Наранбаатар, Дэд ерөнхийлөгч Ц.Цогбаяр, Т.Сумъяа, багийн ахлагч, дасгалжуулагч, Олон улсын мастер Ц.Лхагвасүрэн нар байлаа. Монгол Улсын өсвөрийн баг, тамирчид 2006 оноос эхлэн дэлхийн сурагчдын аварга шалгаруулах тэмцээнд оролцож байгаа бөгөөд өнгөрсөн 10 жилийн хугацаанд таван алт, таван мөнгөн медаль хүртжээ.

## Баасан гарагт амрах эсэхийг өнөөдөр шийднэ

УИХ-ын чуулганы энэ сарын 18-ны хурлаар Нийтээр тэмдэглэх баярын болон тэмдэглэлт өдрүүдийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг хэлэлцсэн. Улмаар арваннэгдүгээр сарын 26-

ны өдрийг Бүгд найрамдах улс тунхагласны баярын өдөр болгон тэмдэглэн бүх нийтээрээ амрахаар шийдвэрлэсэн. Гэвч энэ жилийн арваннэгдүгээр сарын 26 амралтын өдөр буюу бямба гараг таарч байгаа юм.

Тиймээс амралтын өдрийг ажлын өдөр шилжүүлэх буюу баасан гарагт амрах эсэхийг Засгийн газрын хуралдаанаар шийдэхээр болжээ. Засгийн газрын хуралдаан өнөөдөр болох юм.



## Халтиргаа гулгаа нэмэгдэж байгаад иргэд л буруутай гэнэ




МИАТ-ийн онгоцны Новосибирскт гурван цаг саатуулсан гэдэг хэргийн эзэн “Мишээл” группийн захирал, УИХ-ын гишүүн Б.Энх-Амгалан халтиргаа гулгаа нэмэгдээд байгаагийн учрыг олчихсон гэнэ. Тэрбээр энэ талаараа хэвлэлд ярилцлага хүртэл өгөөд амжсан байна. Тодруулбал, “Улаанбаатар хотын иргэд бүгдээрээ машинаа унаад гараад ирж байна. Гэтэл зарим нь сайн жолоо барьж чаддаггүй, дөнгөж жолооны курс төгссөн, зун жолооч болчихсон өвөл машин жолоодож үзээ ч үгүй нөхдүүд явж байна. Тиймээс ч ирээд, мөргөлдчихдөг. Учир нь явж байгаа тээврийн хэрэгслүүдийг дугуй халзан байна. Зуны дугуйтай машин барьж гарч ирээд, зам бөглөөд зогсох, мөргөлдөх, хөдөлгөөн хаачихдаг юм. Тэгээд иргэд гараа хумхичаад “Чи хийх ёстой” гээд суугаад байна” хэмээсэн байна. Эрхэм гишүүний хэлж буйгаар халтиргаа гулгаа нэмэгдэж байгаад цаасаа цэвэрлэж чадахгүй байгаа дарга нар бус ерөөс иргэд л буруутай гэнэ шүү.

# ҮЗЭЛ БОДОЛ

## ДЭЭРХИЙН ГЭГЭЭН ХИВ ДАЛАЙ ЛАМЫН АЙЛЧЛАЛ

# БНХАУ-ЫГ БУХИМДУУЛАВ УУ



Дугаарын **60** мөр

## Ерөөсөө шоронд оръё

Үргэлжлэл.  
Түрүүч нь I нүүрт

Нурууны доод үеийн яс нь цуурч, нугас руугаа түрсэн гэсэн онош сонссон бид нэлээд сандрагдаж, улсын эмнэлгээс чанартай үйлчилгээ хүртэнэ гэсэн минь талаар болж, мэргэжлийн гэх эмч нар нь өвчин намдаах эм бичиж өгөхөөс хэтэрсэнгүй. Гэхдээ суурь өвчтэй эсэхийг нь ч асуулгүй чихрийн шижин өвчтэй хүн удаан хугацаанд ууж болохгүй сөрөг заалттай эмийг бүр гурван сар уу гэж бичиж өгсөн байж таарав. Бид үүнийг дараа нь л мэдсэн. Ер нь тэгээд улсын эмнэлгээс үйлчилгээ авахын тулд асрагч ч болтугай таньдаг байх хэрэгтэй гэсэн бичигдээгүй хууль үйлчилж байдгийг төрөх дөхсөн жирэмсэн эхээс эхлээд бүх хүн л мэддэг гээд хэлчихвэл хэтийндсэн болохгүй. Гэтэл наранд байгаа биднээс нарсанд суугаа ялтангууд хавь илүү үйлчилгээ авдаг юм билээ. Жирийн иргэд дэгсдүүлж хэлбэл, хорооныхоо эмчид эрүүл мэндээ үзүүлэхийн төлөө урт дараалал үүсгэн дугаарладаг бол шоронгийн ялтангууд гуравдугаар шатлалын томоохон эмнэлгүүдийн зөвлөх зэргийн эмчээс ямар нэг дараалал хүлээлгүй эмнэлгийн үйлчилгээ авдаг. Бүр шаардлагатай тохиолдолд яаралтай хагалгаанд хүртэл орчихдог гэж байгаа. Өнгөрсөн жил ах минь бөөрний хагалгаанд орох гэж сар хүлээж байсан юм даг. Энгийн нэг хорооны эмч, зөвлөх зэргийн эмчийн чадварын ялгаа ямар байх нь хэнд ч ойлгомжтой.

Дээрээс нь ямар нэг хүлээлт чирэгдэлгүй үйлчилгээг нэмчихвэл эрхээ хасуулсан нь энгийн иргэдээс илүүтэйгээр найдвартай, хурдан шуурхай хугацаанд эмчлэгддэг гэдгийг тов тодорхой илэрхийлж байна. Түүнээс гадна өнгөрөгч зургадугаар сард ШШШЕГ-ын харьяа будаг нь хангалсан Хорихын нэгдсэн эмнэлэг нээлтээ хийж байсан санагдана. 120 ортой тус эмнэлэгт ШШШЕГ-ын харьяа хот хөдөөгийн хорих ангийн алтнууд ирж, эмчлүүлдэг бөгөөд тус эмнэлэг сүүлийн үеийн тоног төхөөрөмжөөр хангагдсны зэрэгцээ нарийн мэргэжлийн боловсон хүчинтэй талаар тухайн үеийн дарга нь сэтгүүлчдэд хэлж байсан юм. Жирийн иргэдэд үйлчлэх Түлэнхийн төв, Дөрөвдүгээр төрөх гэх мэт царцсан барилгууд хэзээ ашиглалтад орох нь таамаг төдий байхад хэдийнээс “Хүний эрхийг дээдэлдэг” Монголын ялтангууд шинэхэн эмнэлэгт хөлбөрч, шаардлага гарсан үед зөвлөх зэргийн эмчээс “түгжрэлгүй” үйлчилгээ авдаг байх жишээтэй. Тэр бүү хэл, гуравдугаар шатлалын эмнэлэгт үзүүлэхээр дугаарлан зогсох өвчтөнүүдийн урдур онөөх л ялтнууд дайрч, үзүүлж буй жишээг нүдээрээ харж байсан юм даг. Тусгай зориулалтын машинаар тээвэрлүүлж ирэх тэд “Онц хүнд гэмт хэрэгтэн” гэх ганц үгээр өмнүүр дайруулсандаа бухимдах иргэдийн амыг таглаж байсныг санаж байна. Тэгэхээр эрхээ хасуулсан нь хожиж, энгийн иргэд нь зүдэрдэг болсон юм бол ерөөсөө шоронд ордог юм бил үү. Тэгвэл илүү найдвартай эмнэлгийн үйлчилгээ авах бололтой.

### Үргэлжлэл. Түрүүч нь I нүүрт

Тухайлбал, 2002 онд хилээ хааж байсан бол 2006 онд Бээжингээс Улаанбаатар руу хийх нислэгийг нуцалж байсан юм. БНХАУ-ын хувьд Далай ламыг Түвдийн Хятадаас салан тусгаарлахыг эрмэлздэг тэрслүү этгээд гэж үздэг бөгөөд энэ үүднээс түүний аливаа улсад хийх айлчлалыг хүчтэй эсэргүүцээр ирсэн байдаг. Далай лам 1959 онд Хятадын удирдлагыг эсэргүүцсэн бослогын үеэр Түвдийг орхисноос хойш эдүгээ Энэтхэгт амьдарч байгаа аж. Тэгвэл энэ удаагийн түүний Монголд хийх айлчлалтай холбоотойгоор Хятадын Гадаад хэргийн яамнаас мэдэгдэл хийж, хоёр улсын цаашидын харилцааны төлөө Далай ламын айлчлалыг нуцлахыг шаардсан. Учир нь Монголын эрх баригчид эдийн засгаа гүн хямралаас татаж гаргахын тулд Бээжингээс 4.2 тэрбум ам.долларын зээл авахыг эрэлхийлж байгаа юм. Өргөн хэрэглээний барааны үнэ унасан, гадаадын өрөө эргэн төлөх хүндхэн нөхцөл байдал буй Монгол Улс экспортын 90 орчим хувийг эзлэх Хятадаас тусламж авах гаргалгааг хайж байгаа билээ. Монголын буддын лам нар Түвдтэй нягт харилцаатай байдаг бөгөөд буддын шашинт орнууд Далай ламыг ихэд хүндэтгэн дээдэлдэг юм. Далай лам Монголд анх 1979 онд айлчилж байжээ. Сүүлийн арван жилд тохиогоогүй арваннэгдүгээр сарын хамгийн хүйтэн өдрүүдэд ч эдүгээ 81 настай далай ламыг харахаар дэмжигчид нь хэдэн зуун км замыг ажрахгүй туулан ирж байлаа. Тухайлбал, Оросын Сибирис ирсэн Монгол үндэстэн 73 настай Дарьдэрэн баасан гарагт Далай лам айлчлах тухай сонсмогцоо л Улаанбаатар руу хөдөлсөн гэнэ. Харин 125 миллийн цаанаас хүрэлцэн ирсэн 75 настай Болдбаатар “Би хөгшин хүн. Магадгүй сүүлчийн удаа дээрхийн гэгээнтнийг харж байгаа байх” гэж ярьжээ. Далай лам БНХАУ-ын дэмжлэгтэйгээр Хятад компанийн барьсан спорт цогцолборт өнгөрөгч бямба гарагт ном айлдсан байна.

### Монголын эдийн засаг хурдан хугацаанд сэргэх найдваргүй

www.currentbiz.io сайтад Монголын эдийн засгийн өнөөгийн нөхцөл байдлын талаарх мэдээлэл нийтлэгджээ. Үүнд “Зах зээл дэх нүүрсний үнэ огцом өсч байх үед хөрөнгө оруулагчдын анхаарлыг хамгийн ихээр татаж байсан Монгол улс сүүлийн үед бэлэн мөнгөний гачигдалд орсны

улмаас олимпын тамирчдаа ч урамшуулж чадахгүйд хүрсэн. Хямрал зарим талаар Хятадын эдийн засгийн сааралттай ч мөн холбоотой. Тэгвэл хамгийн сүүлийн үеийн мэдээллээр далайд гарцгүй тус улс Олон улсын валютын сангаас тусламж хүсч, зардлаа танах чиглэлээр ажиллаж байгаа аж. Шинэ Засгийн газар зогсон дэд бүтэц, уул уурхайн төслүүдэд гадаадаас хөрөнгө татаж, эдийн засгаа богино хугацаанд тогтворжуулах аргыг эрэлхийлж эхэлсэн. Монголын Үндэсний статистикийн хорооноос мэдээлсэн ДНБ-ний хэмжээ нэгдүгээр сараас есдүгээр сар хүртэл 1.6 хувьтай байх бөгөөд энэ нь өнгөрсөн жилийн мөн үеийнхтэй бараг ижил байгаа юм. Гэсэн ч, экспортын түүхий эдийн үнэ унасны улмаас төсвийн алдагдал нь улам нэмэгдсэн. “Рио Тинто” тэргүүтэй гадны хөрөнгө оруулагчид уул уурхайн шинэ төсөлд хөрөнгө оруулахаа больж эхэлсэн нь төгрөг суларч, татварын орлого буурахад нөлөөлжээ. Түүнчлэн төгрөгийн ханш энэ онд 19 хувиар суларч, өнгөрсөн долоо хоногт бүх цаг үеийн хамгийн доод үзүүлэлт буюу нэг ам.доллар 2479 төгрөгтэй тэнцэв. Үүнээс гадна өнгөрсөн жил төсөв 435 ам.долларын алдагдалтай байсан бол энэ жил 905 ам.доллар болон нэмэгджээ. Монголын эдийн засаг хоёр оронтой тоонд хүртлээ өссөн тэрхүү үе рүү эргэн шилжих бараг боломжгүй. Гэхдээ таван жилийн түүхий эдийн үнийн уналтын дараа

Монголын “судас” аажмаар цохилж эхэлсэн хэдий ч, эрдэс баялагийн зах зээлийг аврах хэмжээнд хүрч чадаагүй л байна. Тиймээс ОУ-ын Валютын сангаас тусламж хүсч, Дэлхийд эдийн засгаараа хоёрдугаарт ордог хамгийн том худалдан авагч улсаас зээл хүсэх аргыг ч эрэлхийлж байгаа. Ямартай ч, Гадаад хэргийн сайд Ц.Мөнхоргил “Зөвхөн яриад байх биш, хийж хэрэгжүүлэх нь чухал байна” гэж ярьсан байгаа юм. Энэ бол коксжих нүүрсний ордог улсын зүгээр л нэг жишээ. Гэвч харамсалтай нь Монголын эдийн засаг хурдан хугацаанд сэргэх найдваргүй. Энэ бол бодит байдал юм” гэсэн байв.

### Далай лам Хятадын эсэргүүцлийг үл тоон, Монголд айлчлав

Оросын “Интерфакс” агентлагын цахим хуудаст Дээрхийн гэгээнтэн далай ламын айлчлалтай холбоотой мэдээ нийтлэгдсэн байх бөгөөд “Түвдийн буддын шашны тэргүүн Далай лам Монголд дөрвөн өдрийн хугацаатай айлчилж буй. Гэвч барууны зарим хэвлэлд энэ удаагийн Далай ламын айлчлалыг БНХАУ-ын тал эсэргүүцсэн талаар мэдээлэл гарчээ. БНХАУ-ын Гадаад хэргийн яамнаас энэ талаар мэдэгдэл хийсэн байх бөгөөд Далай лам аливаа улсын өндөр албан тушаалтнуудтай ямар нэг хэлбэрээр холбоо тогтоохыг эсэргүүцдэг гэдгээ илэрхийлсэн байна. Мөн Монголын талаас Далай ламын

айлчлалыг хориглож, салан тусгаарлах үйл ажиллагаанд нь хувь нэмэр оруулахгүй байхыг шаарджээ. Нөгөөтэйгүүр, Монголын Гадаад хэргийн яамнаас мөн харуу мэдэгдэл хийж, Далай ламын айлчлал Засгийн газартай ямар нэг байдлаар холбоогүй гэх тайлбарыг хийсэн юм. Харин хийдийн зарим лам нар Далай лам шашны үйл ажиллагаагаар бус улс төрийн зорилгоор айлчилж байгааг онцолсон байдаг. Өмнө нь 2011 онд Түвдийн бурхны шашны тэргүүн Монголд айлчилж байжээ” гэжээ.

### Moody's: Монголд хөрөнгө оруулах нь өндөр эрсдэлтэй

Улс орны зээлжих зэрэглэлийг тогтоох томоохон агентлагуудын нэг Moody's манай улсын зээлжих зэрэглэлийг нэг шатаар бууруулсан билээ. Энэ талаарх мэдээлэл www.bloomberg.com сайтад нийтлэгджээ. Үүнд “Ирэх хоёр жилийн хугацаанд Монголын Засгийн газар зээлээ хэрхэн төлөх нь тодорхойгүй байгаа болон цаашид өрийн хэмжээ нэмэгдэх төлөвтэй байгаагай холбогду олон улсын үнэлгээний “Moody's” агентлаг Монголын зээлжих зэрэглэлийг дахин бууруулжээ. Тус агентлаг Монголын зээлжих зэрэглэлийг “B3”-аас “Caal” болгон бууруулснаар тус улсын зээлжих зэрэглэл Барбадос болон Беларусьтай адил түвшинд очлоо. “Caal” нь эрсдэл өндөртэй зэрэглэл юм. Монголын шинэ Засгийн газар эдийн засгийн өсөлт буурсан, төгрөгийн ханш унасан, төсвийн алдагдал нэмэгдсэн зэрэг олон асуудалтай тулгараад байгаа билээ. Үүнтэй холбогду олон улсын Засгийн газар хэмнэлтийн арга хэмжээ авахаа мэдэгдэж, эдийн засгийг тогтворжуулах төлөвлөгөөг гаргасан байна. Мөн өнгөрсөн сард Олон улсын валютын сангаас тусламж авах асуудлыг хэлэлцсэн билээ. Монголын Засгийн газрын санхүүгийн чадавч, эдийн засгийн гадаад байр суурь эрчимтэй доройтсон гэж “Moody's” мэдэгдэлдээ дурдав. Мөн тус улсын Засгийн газар олон талын болон хоёр талын эх үүсвэрийг хавсарган гадаад санхүүжилт авах ажилд хэт анхаарал хандуулж байгаа бөгөөд эдгээрийн аль нь ч одоогийн байдлаар тодорхойгүй байна гэж мэдэгдэлд дурьджээ” гэсэн байна.

### ӨНӨӨДРИЙН ТОП ИШЛЭЛ



“ Үгү өй д і ай аһий аэ аеа дааеаа, і үаеаауу өүй өүй аадиае аауае ааеааа і ү аеаіеа дааао нди е эсүаауе. Еёі аэ аеаеі д аһа өеёеа е аеа эсүае ааеіа. Адаі үі дааодуа Н.Сі деаеі ө°ө°іеё дааіа ааеааа ауае аі аһі і ÷еіү аеіөуіү Адаі үі дааод ÷еіү үіү 0°деі і даі і рі ааеіа. ”

УИХ-ын гишүүн  
**С. Жавхан**

Гэрэл зургийг Г. АРГУУЖИН

# ДЭЛХИЙ

## ЯПОНД БАГАХАН ХЭМЖЭЭНИЙ



# ЦУНАМИ БОЛОВ

Б.ДАВАА

Өчигдөр өглөө буюу орон нутгийн цагаар 06:00 цагийн үед Японы Фүкүшима мужийн далайн эргийн орчимд 7.4 магнитудын хүчтэй газар хөдөлсний улмаас гурван метр

хүртэлх багахан хэмжээний цунами үүсч болзошгүй талаар албаны эх сурвалжууд мэдээлсэн юм. Газар хөдлөлтийн гүн 11.3 км-т байсан бөгөөд чичиргээн бүс нутаг даяар мэдрэгдсэн байна. Байгалийн гэнэтийн аюулт үзэгдэлтэй холбогду Японь цаг уурын хүрээлэн яаралтай мэдэгдэл хийж, Фүкүшима Дайчи цөмийн цахилгаан станц байрладаг тус мужийн эрэг хийгээд Японы зүүн хойд хэсгийн далайн эргийн орчмын бүс нутагт цунами үүсч болзошгүй байгааг онцгойлон анхааруулж байлаа. Мөн далайн эрэг хавийн оршин суугчдыг яаралтай нүүлгэн шилжүүлэхийг уриалсны зэрэгцээ хамгийн ихдээ 1.4 метрийн өндөр хэд хэдэн цунами эргийн орчимд хүрч буйг сэрэмжлүүлсэн юм. Тэгвэл азаар газар хөдлөлтийн дараа иргэдийг нүүлгэн шилжүүлэх, аюулгүй газарт шилжүүлэх арга хэмжээг цаг алдалгүй авч, иргэд ч хувийн бэлтгэл өндөр байсан учир гарз хохирол бага учирчээ. Гамшгийн улмаас 13 хүн хөнгөн бэртэж гэмтсэн талаар тус улсын Эн Эйч Кэй агентлаг уламжилсан байна. Газар хөдлөлтийн дараа тус улсын цаг уурын агентлаг Мияги, Фүкүшима мужуудын эргийн орчимд цунами үүсч болзошгүйг онцолсноос гадна Аомори мужаас Чиба муж хүртэлх номхон далайн эргийн бүс болон Изүгийн арлуудад цунами үүсч болзошгүйг онцгойлон анхааруулсан байдаг. Улмаар номхон далайн эргийн орчмын бүс нутагт багахан хэмжээний цунами ажиглагдсан бөгөөд Сэндай боомтод хамгийн ихдээ 1.4 метр өндөр цунамигийн давалгаа

08:03 цагийн үед үүсчээ. Харин үүнээс өмнө фүкүшима мужийн Сома боомтод 07:06 цагт 90 см, 07:37 цагт Иватэ мужийн Күжи боомтод 80 см, 06:49 цагт фүкүшима мужийн Иваки хотын жижиг боомтуудад 60 см-ын тус тус өндөртэй цунами ажиглагдсан байна. Түүний дараа цаг уурын агентлаг 09:46 цагийн үед Фүкүшима болон Мияги мужид гарсан цунамигийн анхааруулах дохиоллоо зөвлөгөө мэдээллээр сольсны зэрэгцээ дараа нь Иватэ мужаас Ибараги муж хүртэлх далайн эргийн бүс нутагт гарсан цунамигийн анхааруулах дохиоллоо албан ёсоор бүгдийг нь цуцалсан байна. Улмаар цаашдаа далайн усны түвшин өөрчлөгдөж болох хэдий ч, цунамигаас айх зүйл байхгүйг онцолжээ. Нөгөөтэйгүүр, газар хөдлөлтийн дараах түрхэлт Японы 14 хотод ажиглагдсан гэдгийг холбогдох байгууллагаас мэдээлж байгаа юм. Ямартай ч, таван жилийн өмнө буюу 2011 онд Японд урьд хожид байгаагүй гамшиг тохиосон удаатай. Тус улсын зүүн эргийн орчимд хүчтэй газар хөдөлсний улмаас цунами үүсч ихээхэн гарз хохирол дагуулсан бөгөөд 18000 хүн амь нас, эрүүл мэндээрээ хохирсон байдаг билээ. Хэдийгээр энэ удаагийн газар хөдлөлт хор уршиг багатай өнгөрсөн ч Япон дахь манай ЭСЯ-наас Фүкүшима орчимд амьдардаг иргэдтэйгээ холбогдож байгаа аж. Тус улсад манай 6590 иргэн ажиллаж, амьдарч байгаагаас Фүкүшимад 48, Аомори найм, Иватэ 24, Ибараки 162, Мияги 89, Чиба 832 нийт 1163 иргэн оршин суудаг байна.

## Филиппинд есөн настай хүүхдийг ч өршөөлгүй шийтгэнэ

Филиппиний парламентад өргөн барьсан эрүүгийн хэргийн тухай хуулийн зарим хэсэгт шоронд хоригдож ял эдлэх иргэний насны доод хязгаарыг ес байхаар заажээ. Улмаар уг заалтыг эсэргүүцэн НҮБ болон хүний эрхийн байгууллагууд мэдэгдэл хийлээ. Хэлэлцэгдэж буй Эрүүгийн хэргийн тухай хуульд цаазын ялыг сэргээх талаар тусгаснаас гадна үйлдсэн хэргийнхээ хариуцлагыг хуульч насны доод хязгаар 15 байсныг ес болгон багасгах талаар дурьдсан байна. Энэхүү заалтыг тус улсын Ерөнхийлөгч Родриго Дутерте ч дэмжиж буй бөгөөд түүний талын парламентын гишүүд энэ оны дундуур хуулийг санаачилжээ. Дутерте энэ оны тавдугаар сард явагдсан Ерөнхийлөгчийн сонгуульд ялалт байгуулсан гол шалтгаан нь хэдэн мянган хүнийг хамарсан хар тамхины худалдаачдыг цаазлана гэх амлалттай нь холбоотой байсан юм. Гэхдээ хар тамхины наймаачид насанд хүрээгүй хүүхдүүдийг бизнес-тээ ашиглаж, тэднээр тээвэр-лэгчийн үүрэг гүйцэтгүүлдэг байжээ. Тиймээс энэ байдлыг халж, Эрүүгийн хуулийн цоорхойг арилгах үүднээс энэ удаагийн шинэчилсэн хуулийн төслийг парламентаар хэлэлцүүлэхээр өргөн барьсан байна. Филиппин нь 12 нас хүрээгүй хүүхэд ял ногдуулахгүй хэмээн Хүүхдийн эрхийн конвенцэд нэгдэн орсон улсын нэг билээ. Тэгвэл уг хуультай холбоотойгоор НҮБ-ын Хүүхдийн сан мэдэгдэл гаргаж, Филиппинийг олон улсын өмнө хүлээсэн үүргээ дахин баталгаажуулахыг уриалсан байна. Үүнээс гадна Хүний эрхийн байгууллагаас хуулийн төслийг дэмжигч парламентын гишүүдэд хандан шийдвэрээ дахин нэг удаа бодож үзэхийг шаарджээ.

## Хятадад 56 машиныг хамарсан авто осол гарчээ

БНХАУ-ын хойд этгээдийн Шаньси мужийн хурдны зам дээр 56 автомашиныг хамарсан томоохон хэмжээний осол гарсан талаар төрийн мэдлийн Синьхуа агентлаг мэдээллээ. Ослын улмаас хамгийн багаар бодоход 17 хүний амь үрэгдсэн байна. Осол Бээжин хот болон Юньнань мужийн Куньминь хотыг холбосон хурдны зам дээр гарсан байна. Осол гарах үед тухайн хэсэгт цас болон бороо орж байсан учир хальтйргаа гулгаа ихтэй байжээ. Ослын талаарх зураг, бичлэгт томоохон ачааны машинууд байх бөгөөд тэдний зарим нь хөмөрч, зарим нь шатсан дүр зураг дүрсэлэгдсэн байв. Үүнээс гадна 37 хүн гэмтэж бэртэн эмнэлэгт хүргэгджээ. Одоогоор биений байдал нь тогтвортой байгаа гэнэ.

## Трампа ажлаа авсан эхний өдөр л АНУ "TPP"-ээс гарна

АНУ-ын шинэ Ерөнхийлөгч Доналд Трамп ирэх оны нэгдүгээр сард Цагаан ордны тэргүүнээр томилогдон тангарагаа өргөснөөсөө хойш 100 хоногт хийх ажлаа танилцуулаа. Тэрбээр төлөвлөгөөгөө бичлэг хэлбэрээр нийтэлсэн байх бөгөөд эхний өдрөө л "Номхон далай дамнасан түншлэлийн хэлэлцээрээс гарах болно" гэж мэдэгдсэн байна. Номхон далай дамнасан түншлэлийн хэлэлцээрт /TPP/ 12 орон нэгджээ. Тэдгээр улсууд дэлхийн эдийн засгийн 40 хувийг бүрдүүлдэг байна. Мөн тэрбээр нүүрс олборлолтод тавьсан хязгаарлалтыг зөвлөрүүлж, визийн зөрчлийг таслан зогсоохоо амласан билээ. Харин "Obamacare" гэдэг эрүүл мэндийн хөтөлбөр болон Мексиктэй залгаа хил дээр хана барих талаар ямар нэгэн зүйл яриагүй байна. Хоёр долоо хоногийн өмнө тэрбээр Бүгд Найрамдах намаас Ерөнхийлөгчийн сонгуульд нэр дэвшин ялалт байгуулсан нь олон хүнийг цочролд оруулж, АНУ даяар эсэргүүцлийн жагсаал одоо ч өрнөсөөр байгаа юм. Номхон далай дамнасан худалдааны түншлэлийн хэлэлцээрийг 2015 онд байгуулсан бөгөөд Япон, Малайз, Австрали, Шинэ Зеланд, Канад, Мексик зэрэг орнууд нэгдсэн боловч хэлэлцээрийг одоогоор соёрхон батлаагүй байгаа аж. Энэ хэлэлцээр нь эдийн засгийн харилцааг бэхжүүлж, эдийн засгийн өсөлтийг дэмжих зорилготой боловч уг хэлэлцээрийг эсэргүүцэгчид "хэлэлцээрийг нууцаар, томоохон корпорациудад ашигтай байдалар хийсэн" гэж шүүмжилдэг билээ.



## ХАРЬЦУУЛАЛТЫН АРГААР БАРАА ХУДАЛДАН АВАХ ТЕНДЕРИЙН УРИЛГА

Огноо: 2016 оны 11 сарын 23 –ний өдөр  
Тендер шалгаруулалтын нэр: Хүнсний түүхий эд, бүтээгдэхүүн нийлүүлэх  
Тендер шалгаруулалтын дугаар: ӨҮХ17/02  
Өсвөр Үе Хүнс ОНӨААТҮГ нь эрх бүхий эрх бүхий тендерт оролцогчоос Баянзүрх, Хан-Уул, Багахангай дүүргийн сургуулийн өмнөх боловсролын байгууллагуудын 2017 оны 01 дугаар сарын 01 –ны өдрөөс 2017 оны 12 дугаар сарын 31 –ны өдөр хүртэлх Хүнсний бүтээгдэхүүн нийлүүлэх тухай битүүмжилсэн тендер ирүүлэхийг урьж байна.  
ӨҮХ 17/02 Шар будаа  
ӨҮХ 17/03 Хүүхдийн будаа  
ӨҮХ 17/04 Хонь, шар будаа  
ӨҮХ 17/05 Орос гоймон  
ӨҮХ 17/06 Монгол гоймон  
ӨҮХ 17/07 Вафли  
ӨҮХ 17/08 Жигнэмэг  
ӨҮХ 17/09 Ургамлын тос  
ӨҮХ 17/10 Масло  
ӨҮХ 17/11 Аньс  
ӨҮХ 17/12 Нэрс  
ӨҮХ 17/13 Чацаргана

ӨҮХ 17/14 Монгол гурил  
ӨҮХ 17/15 Ааруул, Эзгийг  
ӨҮХ 17/16 Аарц

**Тендерт оролцогчид:**

- Сүүлийн нэг жил буюу 2015 оны баталгаажсан санхүүгийн тайлан болон 2016 оны хагас жилийн баталгаажсан санхүүгийн тайлан
- Ижил төстэй бараа бүтээгдэхүүний нийлүүлэлтийн гүйцэтгэсэн туршлагын талаар мэдээлэл ирүүлэх
- Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн гэрчилгээ

Тендерийг 2016 оны 12 дугаар сарын 13-ны өдрийн 10.00 минутаас өмнө доорхи хаягаар ирүүлэх ба нээлтэнд оролцох хүсэлтэй тендерт оролцогчдыг байшлуудан тендерийг 12 дугаар сарын 13 –ны 11.00 минутанд нээнэ.

Тендерийн баримт бичгийг бичгээр хүсэлтээ гаргаж эргэж төлөгдөхгүй ноцолтгүйгээр иж бүрдэлээр нь 20,000 төгрөгөөр худалдан авна.

Сонирхсон этгээд тендерийн баримт бичиг болон бусад мэдээллийг доорх хаягаар авч болно.

## НЭЭЛТТЭЙ ТЕНДЕРИЙН УРИЛГА

Огноо: 2016 оны 11 сарын 23–ний өдөр  
Тендер шалгаруулалтын нэр: Хүнсний түүхий эд, бүтээгдэхүүн нийлүүлэх  
Тендер шалгаруулалтын дугаар: ӨҮХ17/01  
Өсвөр Үе Хүнс ОНӨААТҮГ нь эрх бүхий эрх бүхий тендерт оролцогчоос Баянзүрх, Хан-Уул, Багахангай дүүргийн сургуулийн өмнөх боловсролын байгууллагуудын 2017 оны 01 дугаар сарын 01 –ны өдрөөс 2017 оны 12 дугаар сарын 31–ны өдөр хүртэлх Хүнсний бүтээгдэхүүн нийлүүлэх тухай битүүмжилсэн тендер ирүүлэхийг урьж байна.

Багц 01-01 Хонины мах  
Багц 01-02 Үхрийн мах  
Багц 01-03 Төмс, хүнсний ногоо  
Багц 01-04 Хуурай сүү  
Багц 01-05 Цагаан будаа  
Багц 01-06 Элсэн чихэр  
Багц 01-07 Орос гурил  
Багц 01-08 Компотны материал

Тендерт оролцогчид:

- Сүүлийн нэг жил буюу 2015 оны баталгаажсан санхүүгийн тайлан болон 2016 оны хагас жилийн баталгаажсан санхүүгийн тайлан

Тендерийг 2016 оны 12 дугаар сарын 23-ны өдрийн 10.00 минутаас өмнө доорхи хаягаар ирүүлэх ба нээлтэнд оролцох хүсэлтэй тендерт оролцогчдыг байшлуудан тендерийг 12 дугаар сарын 23 –ны 11.00 минутанд нээнэ.

Тендерийн баримт бичгийг бичгээр хүсэлтээ гаргаж эргэж төлөгдөхгүй ноцолтгүйгээр иж бүрдэлээр нь 50,000 төгрөгөөр худалдан авна.

Тендер нь түүнийг нэсэн өдрөөс эхлэн 45 хоногийн дотор хүчинтэй байна.

Сонирхсон этгээд тендерийн баримт бичиг болон бусад мэдээллийг доорх хаягаар авч болно.

Улаанбаатар хот, Баянзүрх дүүрэг 19 дугаар хороо, 16-р хороолол “Өсвөр Үе Хүнс” ОНӨААТҮГ-ын өөрийн байранд Утас 456922, менежер Б.Хулан 99294200  
Төлөр хийх хэлбэр: Дансаар тушаана  
Банкны нэр: Улаанбаатар хотын банк  
Дансны дугаар: 2611077920

Улаанбаатар хот, Баянзүрх дүүрэг 19-р хороо, 16-р хороолол “Өсвөр Үе Хүнс” ОНӨААТҮГ-ын өөрийн байранд Утас 456922, менежер Б.Хулан 99294200  
Төлөр хийх хэлбэр: Дансаар тушаана  
Банкны нэр: Улаанбаатар хотын банк  
Дансны дугаар: 2611077920

# ОНЦЛОХ ХУУДАС

## Speak out



Гэтэл согог судлалын үндэсний төв. 2016.11.21-н 14:30 цаг

# АЛБАН БАЙГУУЛЛАГУУД 50 МЕТР ОРЧМЫН ЦАСАА ЦЭВЭРЛЭ

Н.БАТЗАЯА

“Хот тохижилт, цэвэрлэгээний талаар байгууллага, аж ахуйн нэгж, иргэдээс дагаж мөрдөх журам”-ын дагуу иргэн, аж ахуйн нэгж байгууллагууд өөрийн эзэмшил, ашиглалтад байгаа газар болон орчны 50 метр хүртэлх нийтийн эзэмшлийн зам талбайд ногоон байгууламж байгуулах, арчилгаа цэвэрлэгээг хариуцаж, өвлийн улиралд хун томилж цас, мөсийг тухай бүрт нь арилгаж, хальтиргаа гулгаа үүсгэлгүйгээр, иргэдийн тав тухтай амьдрах орчин нөхцөлийг бүрдүүлэх үүрэг хүлээсэн байдаг. Гэтэл сүүлийн үед гудамж талбайд хальтирч унаж, улмаар гар, хөлөө гэмтээх нь ихэссэн. Тиймээс бид энэ удаа ГССҮТ-д үйлчлүүлж буй иргэдтэй уулзаж “Speak out” бэлтгэлээ.

Гэрэл зургийг Г.АРИУУЖИН



**Ц.Амарсанаа:** Аргаа барсандаа өвчин намдаах эм уугаад л хүлээж байна шүү дээ

-Би ач хүүгээ сургуулиас нь авах гэж яваад хорооньхоо урд хальтираад уначихсан юм. Манай хорооны байр, орхийн эмнэлэг хоёр ойролцоо байдаг юм. Тэгээд орхийн эмнэлэг рүүгээ ороод үзүүлэл яаралтай гэмтлийн эмнэлэг яв гэсэн. Тэгээд л энд ирээд үзүүлж байна. Хэрвээ албан байгууллагын гадаа

хальтирч унавал эмчилгээнийхээ төлбөрийг авдаг гэж би мэдэхгүй. Одоо тэгвэл хороондоо хандаж эмчилгээнийхээ төлбөрийг авмаар юм байна. Ер нь тэр хавийн ойр орчим маш их цастай байдаг. Хальтиргаа, гулгаа ихтэй. Явган хүн явахад их төвөгтэй шүү дээ. Өнгөрсөн жил би бас хальтирч унаж байсан. Гэхдээ гар, хөлөө гэмтээгээгүй. Энэ жил дахиад хальтирч унаад гараа хугалчихлаа. Ерөөсөө хорооны тэр хавийг цэвэрлэхгүй байна шүү дээ. Төр засгийн удирдлагууд, нийслэлийн Засаг дарга юу хийж байна вэ. Би өглөөнөөс эхлээд л гэмтлийн эмнэлэгт зургаа авахуулах гэж

дугаарлаж зогслоо. Дугаар нь дийлдэхгүй болохоор аргаа барсандаа өвчин намдаах эм уугаад л хүлээж байна шүү дээ. Өвлийн улирал болж байна. Хальтиргаа, гулгаа ихсэн гэж мэдэж баймаар юм даа. Ядаж зураг авдаг рентгенний аппаратыг нь хоёр газар ажиллуулж болно доо. Нээрээ УИХ-ын гишүүд, тэр Эрүүл мэндийн сайд эд нар уншдаг бол ард түмэн чинь өвчин намдаах эм уугаад биеэ үзүүлэх гэж дугаарлаж зогсоцгоож байна шүү. Үүнийг нэг анхааралдаа аваач ээ гэж хүсмээр байна. Ийм байж болохгүй шүү дээ. Бүхэл бүтэн улсын гэмтлийн нэгдсэн төв эмнэлэг гэрчээд ирсэн

үйлчлүүлэгчиддээ ч бүрэн хүрч ажиллаж чадахгүй хэдэн цагаар өвчтэй хүмүүсийг хүлээлгээд л байж байна. Та нар ч гэсэн харж байгаа биз дээ. Байдал ямар байгааг. Хүмүүсийн яаж дугаарлаж байгаа зургийг нь авч тэр эрх мэдэлтэй хүмүүст нь харуулайсай л гэж хүсч байна. Энд ирсэн ихэнх хүмүүс л хальтирч унаад гар хөлөө хугалсан байна. үнэхээр гадуур явахын хэрэг алга. Тэглээ гээд ажилгүй хүн байгаа биш. Намайг гадуур явахаа байчихвал ачиг маань хэн сургуулиас нь авах юм. Эцэг, эх нь ажилтай шүү дээ. Албан байгууллагууд ч гэсэн үүргээ ухамсарлаад

ойр орчмынхоо цас, мөсийг цэвэрлэх ч хэрэгтэй. Хэн хэн нь үүргээ ухамсарлахгүй болохоор ард иргэд л хохирч байна. Бид ч гэсэн цас орохоор гэртээ шавхай тарихгүй гээд хашаан дахь цасаа цэвэрлэдэг биз дээ. Түүнтэй л адил хүмүүсийг хальтирч унаж, бэртэхээс сэргийлээд цас, мөсөө цэвэрлэх ёстой. Арай л дэндүү байна аа. Энэ төр засгийн хүмүүс өөрсдөө гудамжаар яваад хальтирч унаад гараа хугалаад гэмтлийн эмнэлгээр яваад үзээсэй, тэгж байж л зовлонг нь ойлгож байх даа. Хэлэх ч үг олохгүй юм. Одоо энэ цасаа л цэвэрлэх хэрэгтэй.



**Б.Мөнх-Эрдэнэ:** Хальтиргаа маш их байна

-Би дэлгүүр орж юм авах гэж байсан юм. Нарангийн голын 42 дугаар сургуулийн урд талын дэлгүүрийн урд хальтираад уначихсан. Тэгээд л гараа хугалчихлаа. Манай тэр хавнар аймаар хальтиргаатай.

Хичээлдээ явахад маш хэцүү байдаг. Замаар гарна. Хальтирч уначих гээд л. Ерөөсөө цасаа цэвэрлэдэггүй. Би эмчилгээнийхээ төлбөрийг авдаг талаар мэдэхгүй. Ээждээ хэлмээр юм байна.

Одоо би эмчилгээнийхээ төлбөрийг гаргуулж авна. Яагаад заавал зүв зүгээр явж байгаад эрүүл мэндээрээ хохирох ёстой юм. Яахав байгалийн үзэгдэл ч гэсэн тэрийг цэвэрлэх, илүү аюултай болгохоос нь сэргийлэхийн тулд хуулиараа зохицуулаад өгсөн байгаа биз дээ. Албан байгууллага, аж ахуйн нэгж ойр орчмынхоо талбайг цэвэрлэх ёстой гээд. Хэрвээ тэр байгууллага үүргээ ухамсарлаад цасаа цэвэрлээд, мөсөө арилгачихсан бол би өдийд энд зогсож байхгүй шүү дээ. Одоо тэнд хэдэн хүн хальтирч унах юм бүү мэд. Тэр байгууллага

дээр нь цэвэрлэж л авахгүй бол. Энэ зам чинь улам л толийгоод байх шинжтэй байна л даа. Би бас нэг зүйл хэлмээр байна. Энэ гэмтлийн эмнэлгийн ачаалал үнэхээр хүнд байна. Би өглөө 10:00 цагт ирсэн. Эмч үзээд гарныхаа зургийг авахуулаад ир гэсэн. Тэгээд одоо болтол оочерлож байна. Одоо 13:00 цаг өнгөрч байна. Арай л дэндүү. Тэгээд яасан юм гэсэн нэг аппарат нь эвдэрсэн гэнэ. Энэ тал дээрээ ч гэсэн анхаараасай гэж хүсч байна.



**Ч.Буянхишиг:** Дэлгүүрийн эздэд хандаж, эмчилгээнийхээ төлбөрийг авна

-Албан байгууллагын өмнө хальтирч унаад хөл гараа гэмтээсэн бол эмчилгээнийхээ төлбөрийг 100 хувь гаргуулдаг талаар би мэднэ. Угаасаа журмандаа байгууллага, аж ахуйн нэгжүүд 50 метр доторх талбайг цэвэрлэж, цас, мөсийг нь арилгах ёстой гэж заасан байдаг.

Энэ талаар өмнө нь сонсож байсан. Гэхдээ сая хальтирч унаад гараа хугалаад юун тэр талаар бодох шууд л наашаа эмнэлэг рүү ирлээ. Би 100 айлын Иргэний бүртгэл мэдээллийн төв орсон юм. Тэндээс гараад тэнд байдаг Хасбанкны эсрэг талын дэлгүүрийн урд хальтираад уначихсан. Тэгээд босч чаддаггүй. Ашгүй нэг залуу ирж татаж босголоошт. Гараа харсан гар маань бүр хавдчихсан байсан. Тэгээд л гараа хугалсан байна гэж мэдсэн л дээ. Сая хальтирч унаад нэр усыг нь ч сайн анзаарсангүй ямар Тамга гэсэн нэг тийм л газар байсан.

байж байдаг. Манайх Улиастайд байдаг. Би дүүгээ сургуулиас нь авах гэж байгаад хальтирч унаад гараа хугалчихсан юм. Одоо гарныхаа зургийг авахуулах гээд л хүлээж байна. Ер нь цасаа цэвэрлэхгүй байгаа. Замынхаа цэвэрлэхгүйгээр болж машинууд хүртэл хоорондоо мөргөлдөөд осол их гарч байх шиг байна лээ. Цас цэвэрлэх хүн хүч дээрээс нь багаж, хэрэгсэл дутмаг байна л даа. Ингэж хэдэн ажилчдынхаа махыг идэж байхаар цас цэвэрлэдэг хэдэн машин л авчих хэрэгтэй. Манай

цэвэрлэхгүй бол гулгаа улам л үүснэ дээ. Хүн явсаар байгаад бүр толийчихсон байна билээ. Одоо ч тэгээд гадуур явалтгүй байна. Хальтиргаа, гулгаа маш их. Нэг бол машин доогуур орчих гээд байна шүү дээ. Явган хүний гарцаар гарч байхад л машинууд гулгаж ирээд дайрчих гээд байна. Өглөө намайг явж байхад нэг эмэгтэй бас тэгээд мөргүүлэхээ дөхсөн. Нөгөө машин нь цаашаа дараад бас цаад талынхаа машиныг мөргөнгөө алдсан. Энэ маягаараа байвал хэцүүхэн л юм болох байх. Улам хүйтэрнэ. Дахиад цас орно гээд анхааруулаад байсан. Цасаа бага

чиллэн барин байж гарныхаа зургийг авахуулахгүй шүү дээ. Шууд л дулаахан газар ороод л түргэн шуурхай үйлчилгээ аваад л гарч байгаа. Иргэддээ анхаарал хандуулах хэрэгтэй байна. Энд өндөр настай хүмүүс ч байна. Жоохон хүүхдүүд ч байна. Миний үеийн хүмүүс ч байна. Төр засгийнхан байдаг бол гэмтлийн эмнэлгээрээ ирээд нөхцөл байдалтай танилцчих л хэрэгтэй.



**Г.Оюун:** Албан байгууллагууд нь л гадаах цасаа цэвэрлэдэггүй

-Тийм. Би мэднэ. Гэхдээ манай албан байгууллагууд ер нь л гадаах цасаа цэвэрлэдэггүй шүү дээ. Яахав төв зам дагуу байгууллагууд нь цэвэрлэдэг л байх. Гэхдээ л ингээд хараад байхад ихэнх нь л цэвэрлээгүй

нийслэл чинь жижигхэн шүү дээ. 2-3 ширхэг цас цэвэрлэдэг машин байхад л болно шүү дээ. Сүүлийн үед фэйсбүүкээр ч их явж байсан. Тийм машин авчихад л болно. Тэгээд цасаа цэвэрлэхгүй хүмүүс унаад, бэртээд байхгүй байх. Тэгээд бас гэмтлийн эмнэлгийн ачаалал маш их байна. Түүнээс болж тоног төхөөрөмж хүрэлцэхгүй байна. Би гэхэд л гарныхаа зургийг авахуулах гэж бараг нэг цаг дугаарлаж байна. Энэ тал дээр ч гэсэн анхаарах хэрэгтэй. Манай улс чинь жилийн дөрвөн

улиралтайгаараа онцлогтой. Хүн бүр л өвөл хальтиргаа, гулгаа ихэсдэг гэдгийг мэдэж байгаа. Тийм болохоор ядаж гар, хөлөө хугалаад ирсэн хүмүүсийг хүлээж авдаг, эмчилдэг эмнэлгийнхээ тоног төхөөрөмжийг хүрэлцээтэй болгочих хэрэгтэй. Одоо тэгээд хүйтэн коридорт хэдэн цагаар л оочерлоод зогсож байна. Ер нь зовохыг нь ард иргэд л зовж, янцлаглахыг нь төр засгийнхан л хийж байх шиг байна даа. Тэд нар гар хөлөө хугалсан ч хувийн эмнэлэгт ямар ч оочер дугааргүй, даарч, хөл гараа

улиралтайгаараа онцлогтой. Хүн бүр л өвөл хальтиргаа, гулгаа ихэсдэг гэдгийг мэдэж байгаа. Тийм болохоор ядаж гар, хөлөө хугалаад ирсэн хүмүүсийг хүлээж авдаг, эмчилдэг эмнэлгийнхээ тоног төхөөрөмжийг хүрэлцээтэй болгочих хэрэгтэй. Одоо тэгээд хүйтэн коридорт хэдэн цагаар л оочерлоод зогсож байна. Ер нь зовохыг нь ард иргэд л зовж, янцлаглахыг нь төр засгийнхан л хийж байх шиг байна даа. Тэд нар гар хөлөө хугалсан ч хувийн эмнэлэгт ямар ч оочер дугааргүй, даарч, хөл гараа

улиралтайгаараа онцлогтой. Хүн бүр л өвөл хальтиргаа, гулгаа ихэсдэг гэдгийг мэдэж байгаа. Тийм болохоор ядаж гар, хөлөө хугалаад ирсэн хүмүүсийг хүлээж авдаг, эмчилдэг эмнэлгийнхээ тоног төхөөрөмжийг хүрэлцээтэй болгочих хэрэгтэй. Одоо тэгээд хүйтэн коридорт хэдэн цагаар л оочерлоод зогсож байна. Ер нь зовохыг нь ард иргэд л зовж, янцлаглахыг нь төр засгийнхан л хийж байх шиг байна даа. Тэд нар гар хөлөө хугалсан ч хувийн эмнэлэгт ямар ч оочер дугааргүй, даарч, хөл гараа

## ДУГААРЫН СУРВАЛЖЛАГА

Н.БАТЗАЯА

Хахир хүйтэн өвлийн цаг Хирсэнтэй холбогдуулан нийслэлчүүд амьсгаа авах зайгүй сандралдан нааш, цааш гүйлдэх болов. Учир нь өнгөрсөн долоо хоногуудад орсон цасны улмаас хальтиргаа, гулгаа ихэсч, ГССҮГ-ийг зорих иргэдийн тоо ч эрс нэмэгдсэн талаар эмч, мэргэжилтнүүд анхааруулаад буй. Нийслэл даяар л хүн бүрийн өдөр тутмын амьдралд саад учруулах болсон машин зам болон гудамжин дахь цас, мөснөөс салах тухай хэлэлцүүлэг зохиол ертөнцөөр хөвөрч эхэлсэн. Зарим нэг нь техник, технологийн эрин үед амьдарч байж одоо болтол хүрээ, давснаасаа салахгүй байна. Цас арилгагч машин авчихаач хэмээн санал дэвшүүлээд амжсан.

Энэ явдал хэрээс хэтэрч хотын дарга нь өнгөрсөн хоногт хэдэн удаа цас орсныг тоолж, эцэс сүүлдээ өөрөө нөгөө



Гэрэл зургийг Г.АРТУУЖИHN

## ТОМУУГИЙН ИДЭВХЖИЛ ЭХЭЛСЭН Ч

хүрээ бариад цасаа цэвэрлэв. Улаанбаатарт ийн элдэв хөгтэй ч гэх үү, эмгэнэлтэй ч гэх үү үйл явдал үргэлжилж байх хооронд аль хэдийнэ томуугийн вирус идэвхжээд эхэлжээ. Тиймээс “Монголын мэдээ” сонин Томуугийн вирус болон түүнээс хамгаалах вакцин тойрсон асуудлыг хөндөн энэ удаагийн дугаарын сурвалжлагаа бэлтгэлээ.

Амралтын өдөр 200-250 хүүхэд хүлээн авахад хандаж байна

Нэгэнтээ хүйтний улирлын эхний сар шувтарч байгаа энэ цагт өдөртөө -20, шөнөдөө -30 хэм хүрч эхэлсэн. Цаашид ч улам хүйтэрнэ гэдгийг Ус, цаг уур, орчны судалгаа мэдээллийн хүрээлэнгээс анхааруулаад байгаа билээ. Тэгвэл хүйтний эрч чангарч эхэлмэгц л нийслэлийн хүүхэд, багачуудын дунд томуу, томуу төст өвчний халдвар ихэсдэг. Тэр дундаа 0-6 настай хүүхдүүд ханиад, томуугаар өвчлөх нь элбэг байдаг. Харин ойрын өдрүүдэд хальтиргаа, гулгаа, цас арилгах энэ тэр гэсээр хүүхэд, багачуудыг хоморголон өвчлүүлдэг ханиад, томуугийн талаар түр мартсан бололтой. Тиймээс манай сурвалжлах хэсэг бодит байдал ямар байгаа талаар сурвалжлахаар Баянзүрх дүүргийн нэгдсэн эмнэлгийн

зорьсон юм. Учир нь томуу, томуу төст өвчний идэвхжилын үеэр дүүргийн өрхийн болон нэгдсэн эмнэлгүүд ачаалалтай ажилладаг. Өнгөрсөн жил гэхэд нэг орон дээр 2-3 хүүхэд хэвтэн эмчлүүлсэн тохиолдол ч гарч байсан удаатай. Тиймээс иргэдэд анхан шатны тусламж үйлчилгээг хүргэдэг дүүргүүдийн нэгдсэн эмнэлгийн нэгийг зорьсон минь энэ. Биднийг очих үед Баянзүрх дүүргийн нэгдсэн эмнэлгийн хүлээн авах хөл хөдөлгөөн ихтэй байлаа. Үйлчлүүлэгчдийн ихэнх хувь нь 0-6 насны хүүхдүүд байх аж. Хүлээн авахын коридорын гол хэсэгт урт ногоон өнгийн сандлыг дөрвөн өнгөө болгон тавьжээ. Мөн коридын хана дагуу сандлуудыг ч байрлуулсан харагдав. Энд тэндгүй халуундаа уйлж, ээж, аавдаа тэврүүлэн үе үе ханиах үзүүлдэг байх аж. Зарим нэг нь хүчтэй ханиалгандаа цээж нь өвдсөн бололтой гиншигнэн, зарим нэг нь нусаа татан өөрийнхөө үзүүлдэг ээлжийг хүлээн суусан. Энэ оны арваннэгдүгээр сар дуусах дөхөж байгаа ч эмнэлгийн ачаалал их байгаа гэдэг нь үзүүлэхээр ирэх хүмүүсээс л мэдэгдэж байсныг нуух юун. Хүлээн авахын сувиллагч нар ч хүн их байгаа талаар бидэнд хэлсэн. Хөх комбиназон дотуур ногоон өнгийн цамц өмссөн хоёр настай болов уу гэмээр

...Бид ажлын өдрүүдэд нэг өдөрт гэхэд л 100-150 хүүхэд хүлээн авдаг. Харин амралтын өдрөөр 200-250 хүүхэд хандаж байна. 103-ын түргэн тусламжаар 3-4 хүүхэд ирдэг. Ер нь хэвтэх бичигтэй ирсэн хүүхэд болгоныг хэвтүүлэх боломжгүй. Яагаад гэвэл эмнэлгийн ор хүрэлцэхгүй. Манай эмнэлгийн “Хүүхдийн тасаг” гэхэд л 150 ортой. Гэсэн ч одоогийн байдлаар 174 хүүхэд хэвтэн эмчлүүлж байна...

жаал хүү үе үе хүчтэй ханиалган суугаа харагдав. Тэр хатгаа бүсч эмнэлэгт хэвтэж байгаад өнгөрсөн долоо хоногт гарсан гэнэ. Гэхдээ хатгаа нь дахин сэдэрч буцаж иржээ. Тэгэхдээ дахиад л эмнэлэгт хэвтэн эмчлүүлэхээс өөр аргагүй болсон аж. Ханиад хүрснээс болоод цэцэрлэгтээ ч явахгүй байгаа талаар түүний ээж бидэнтэй цөөн хором ярилцсан юм. Энэ хүү бол ганцхан жишээ. Цэнхэр халадтай сувиллагч бүсгүй ирсэн хүүхдүүдийн мэдээллийг бүртгэж авах бөгөөд ээж, ааваас нь “Хүүхэд нь одоо ямар зовиур илэрч байна” гэж асуух аж. Харинд нь эцэг, эхчүүд “Халуурч байна. Хэдэн өдөр халуураад өрхийн эмчдээ үзүүлэл хэвтэх бичиг

хийж өглөө” хэмээн хариулж байлаа. Үнэхээр та энэ өрөөнд тусч амьсгаа л сонсох үгсийн нэг бол “өндөр халуурч байна” гэх үг. Бид хүлээн авахын ээлжийн эмчтэй уулзах гэж 30 гаруй минут хүлээв. Тэр хугацаанд хүлээн авахыг зорьж ирэх хүмүүсийн тоо тасрахгүй л байлаа. Энд дахин нэг зүйлийг яаралтай тусламжийн төвийн хүүхдийн эмч Б.Будтай уулзсан юм. Тэрбээр, “Хүлээн авахын ачаалал их байна. Бид ажлын

өдрүүдэд нэг өдөрт гэхэд л 100-150 хүүхэд хүлээн авдаг. Харин амралтын өдрөөр 200-250 хүүхэд хандаж байна. 103-ын түргэн тусламжаар 3-4 хүүхэд ирдэг. Ер нь хэвтэх бичигтэй ирсэн хүүхэд болгоныг хэвтүүлэх боломжгүй. Яагаад гэвэл эмнэлгийн ор хүрэлцэхгүй. Манай эмнэлгийн “Хүүхдийн тасаг” гэхэд л 150 ортой. Гэсэн ч одоогийн байдлаар 174 хүүхэд хэвтэн эмчлүүлж байна. Тийм болохоор хүнд гэсэн хүүхдээ л хэвтүүлдэг. Ачаалал ерөнхийдөө ихэссэн. Зарим эцэг, эхчүүд өрхийн эмнэлэгтэй үзүүлсэн чинь болохгүй байна аа гээд л хүүхдээ аваад ирдэг” гэв. Тус эмнэлгийн хүлээн авахад хандаж буй хүүхдүүдийн 80-90 хувь нь ханиад томуу туссан хүүхдүүд эзэлж байна гэдгийг тэрбээр онцолсон юм. Харин үлдсэн 10-20 хувийг нь шингэн алдалт, суулгалттай туссан хүүхдүүд эзэлж байна гэдгийг тэрбээр онцолсон юм. Харин үлдсэн 10-20 хувийг нь шингэн алдалт, суулгалттай туссан хүүхдүүд эзэлж байна гэдгийг тэрбээр онцолсон юм. Харин үлдсэн 10-20 хувийг нь шингэн алдалт, суулгалттай туссан хүүхдүүд эзэлж байна гэдгийг тэрбээр онцолсон юм. Харин үлдсэн 10-20 хувийг нь шингэн алдалт, суулгалттай туссан хүүхдүүд эзэлж байна гэдгийг тэрбээр онцолсон юм.

сүлдан халуунаа үзүүлэхгүй хэмээн нэгэн жаал хүү уйлж харагдав. Энэ хүү мөн л ханиад хүрч, халуурсан бөгөөд мөн хэвтэх бичигтэй. Тэрбээр энэ жил нэгдүгээр ангид орсон гэнэ. Монгол Улсын Үндсэн хуульд заасны дагуу хүн бүр эрүүл мэндээ хамгаалуулах, эмнэлгийн тусламж авах эрхтэй. Гэхдээ эмнэлгийн тоотой хэдхэн орноос шалтгаалан өрхийн эмчийн хэвтэх бичигтэй хүлээн авахад ирсэн хүүхэд бүр эмнэлэгтээ хэвтэж чадахгүй байна.

Ханиад хүрсэн хүүхдүүдийг цэцэрлэгээс нь чөлөөлж байна гэв

Томуугийн вирус амьсгалын замаар халддаг. Халдвар авсан хүн ханиах, найтаах үед халдварлагдсан агаар дусал гар, эд зүйсийн гадаргууд бууж, харин жин багатай жижиг хэрсүүд нь агаарт тогтон үлддэг байна. Харин бусад хүмүүс тэр агаараар амьсгалах, эсвэл халдварлагдсангаар, гадаргуутай хүрэлцсний улмаас халдвар авдаг аж. Тиймээс бага насны хүүхдүүдийн халдвар авч байгаа хамгийн эхний газар бол яах аргагүй цэцэрлэг. Нэг хүүхэд л цэцэрлэгтээ ханиадтай ирчихэд бусад нь халдвар авах тохиолдол их байдаг. Иймд манай

## АШИГТ МАЛТМАЛЫН ТУСГАЙ ЗӨВШӨӨРӨЛ ЭЗЭМШИГЧДИЙН АНХААРАЛД

Ашигт малтмалын тухай хуулийн 34 дүгээр зүйлийн 34.2, 34.6, 34.7 дахь хэсэгт заасны дагуу тусгай зөвшөөрлийн ээлжит жилийн төлбөрийг алдангийн хамт төлөөгүй, мөн хуулийн 31 дүгээр зүйлийн 31.1 дэх заалтыг зөрчсөн дараах аж ахуйн нэгжийн ашигт малтмалын хайгуулын

тусгай зөвшөөрлүүдийг Ашигт малтмалын тухай хуулийн 56 дугаар зүйлийн 56.1.2 дахь хэсэгт заасныг үндэслэн АМГТГ-ын Кадастрын хэлтсийн даргын 2016 оны 11 дүгээр сарын 18-ны өдрийн 148 дугаар шийдвэрээр цуцалсныг мэдэгдэж байна.

№	Тусгай зөвшөөрлийн төрөл, дугаар	Анх олгосон огноо	Аймаг, хот	Сум, дүүрэг	Талбайн нэр	Аж ахуйн нэгжийн нэр
1	MV-011810	2006.06.05	Увс	Тариалан	Талын салаа-1	Ордос трейд ХХК
2	MV-015603	2010.06.24	Өмнөговь	Баян-Овоо	Тогоот	Паламиномайнинг ХХК
3	XV-015149	2009.09.21	Дорноговь	Мандах, Сайхадулаан	Дулаан	Геоканон төв ХХК
4	XV-017843	2015.09.24	Өвөрхангай	Баруунбаян	Таац	Далайнтотгох ХХК
5	XV-010532	2005.09.29	Хэнтий	Мөрөн	Хавтгай уул	Их мөрөн шинэ ван ХХК
6	XV-018923	2015.09.30	Ховд	Мянгад	Улаан	Оюу-Орд ХХК
7	MV-017394	2013.10.03	Хэнтий	Өмнөдэлгэр	Төгс	Навчиг айрон майнинг ХХК
8	XV-014982	2009.07.07	Дорнод	Дашбалбар	Эрдэнэтөлгой-1	Эрэскай ХХК
9	XV-013745	2008.05.26	Дорноговь	Даланжаргалан	Хайргат	Хааннутаг ХХК
10	XV-013750	2008.05.26	Дорнод	Матад	Ганган	Эф Эф Эм ХХК
11	XV-013744	2008.05.26	Баян-Өлгий	Буянт, Толбо	Цагаан салаа	ОАЭ ХХК

АМГТГ-ЫН КАДАСТРЫН ХЭЛТЭС

## АШИГТ МАЛТМАЛЫН ТУСГАЙ ЗӨВШӨӨРӨЛ ЭЗЭМШИГЧДИЙН АНХААРАЛД

Ашигт малтмалын тухай хуулийн 34 дүгээр зүйлийн 34.2, 34.6, 34.7 дахь хэсэгт заасны дагуу тусгай зөвшөөрлийн ээлжит жилийн төлбөрийг алдангийн хамт төлөөгүй, мөн хуулийн 31 дүгээр зүйлийн 31.1 дэх заалтыг зөрчсөн дараах аж ахуйн нэгжийн ашигт малтмалын хайгуулын

тусгай зөвшөөрлүүдийг Ашигт малтмалын тухай хуулийн 56 дугаар зүйлийн 56.1.2 дахь хэсэгт заасныг үндэслэн АМГТГ-ын Кадастрын хэлтсийн даргын 2016 оны 11 дүгээр сарын 18-ны өдрийн 147 дугаар шийдвэрээр цуцалсныг мэдэгдэж байна.

№	Тусгай зөвшөөрлийн төрөл, дугаар	Анх олгосон огноо	Аймаг, хот	Сум, дүүрэг	Талбайн нэр	Аж ахуйн нэгжийн нэр
1	XV-010526	2005.09.24	Дорноговь	Улаанбадрах	Ганган дэл	Андхуйшан ХХК
2	XV-014766	2009.03.05	Архангай	Цэнхэр	Цагд-Уул	Вартбург ХХК
3	XV-018109	2015.05.19	Баян-Өлгий	Алтанцөгц, Баяннуур	Алтан	Талын харгүй ХХК
4	XV-018365	2015.07.27	Увс	Өлгий, Өмнөговь	Сэрүүн	Элчиг минерал ХХК
5	XV-013946	2008.07.31	Дорноговь	Айраг	Судалт	Бостон-Интернэшл ХХК
6	MV-015040	2009.08.03	Дорноговь	Айраг	Хадан-Ус	Мизү ХХК
7	MV-017362	2013.08.13	Дархан-Уул	Дархан, Орхон	Их булан	Сонголон хайрхан ХХК
8	MV-017596	2014.08.19	Дорноговь	Иххэт	Цагаан элгэн	Болоргол ХХК
9	XV-012645	2007.08.20	Булган	Хишиг-Өндөр	Баян хар уул	Эйч Эс Дн ХХК
10	XV-017916	2015.08.21	Өмнөговь	Булган, Мандал-Овоо	Өмнө	Юнайтедбизнес ХХК
11	MV-015642	2010.08.23	Увс	Түргэн	Хээр морьт	Тоосгон-Уул ХХК

АМГТГ-ЫН КАДАСТРЫН ХЭЛТЭС



# NO STRESS

АМЖИЛТЫН ЭЗЭН

## Тив, дэлхийн аварга М.АНХЦЭЦЭГТ эх орондоо ирлээ



Н.БОЛД

Рио-2016 зуны Олимпын наадмын хүндийн өргөлтийн төрөлд М.Анхцэцэг гэдэг 19-хөн настай охин оролцож, шилдэг

наймд шалгарсан. Түүнээс хойш ямар ирээдүйтэй тамирчин болохоо дахин дахин баталсаар байна. Тэрбээр хэдхэн хоногийн зайтай хоёр алтан медаль хүртсэн. Японд болсон хүндийн өргөлтийн Азийн аварга шалгаруулах тэмцээнд түрүүлсэн бол хэдхэн хоногийн дараа Мексикт очиж, оюутны дэлхийн аваргаас алтан медаль авсан билээ. Тэрбээр зардал мөнгөний гачаалаас болоод дасгалжуулагчгүйгээр ганцаараа явсан ч тэрбээр залуучуудын ангиллын тэмцээнүүдэд тасархай түрүүлж чадсан юм.

Тэгвэл тив, дэлхийн аварга М.Анхцэцэг өнгөрсөн даваа гарагт эх орондоо ирлээ. Түүнийг "Алдар" спорт хорооны хамт олон болоод аав, ээж, төрөл төрөгсөд болоод хүндийн өргөлтийн холбооныхон угтаж авсан юм.

Түүний "Рио 2016" олимпын наадмын үеэр тохойдоо авсан үл ялиг бэртэл нь сүүлд оролцсон оюутны ДАШТ-ий үеэр сэдэрсэн ч зургийг нь авахуулж, тодорхой эмчилгээ хийлгээгүй байгаа тул гэр бүлийнхэн болон багш нь эмнэлэг авч явахаар яарсан. Тэрбээр эмнэлэг явахын өмнө хэвлэлийнхэнтэй цөөн хором ярилцаж, сэтгэгдлээ илэрхийлсэн. М.Анхцэцэг "Долоон хоногийн дотор болсон хоёр ч том тэмцээнд түрүүлж, залуучуудын Азийн аварга, оюутны дэлхийн аварга болсондоо баяртай байна. Арваннэгдүгээр сарын 11-нд эх орноосоо мордож, яг арав хоногийн дараа эх орондоо ирлээ. Оюутны ДАШТ-д оролцох үедээ зүүн гараа бэртээсэн. Сарвуу руугаа хавдсан байгаа. Багшгүй ганцаараа явах хэцүү байсан.



Багшийгаа их үгүйлсэн. Бусад орны тамирчид багшгүй явж байгаа юм уу, яагаад ганцаараа явж байгаа юм бэ гээд их туслаж, дэмжиж байсан.

Манай спортын онцлог бол ганцхан дасгалжуулагч ч багаддаг, албаны бусад хүмүүс хамт явах шаардлагатай байдаг спорт юм. Гараа бэртээсэн учраас ачаагаа авч явахаас эхлээд асуудал гарч байсан" хэмээн ярьсан юм. Мөн

гадаадаас санал ирж байгаа талаар "Ирсэн нь үнэн. Тодорхой хэмжээнд өндөр үнэ хэлсэн ч гадуур яваад байгаа мэдээлэл шиг бишээ. Миний гол зорилго бол мөнгө биш, дэвжээн дээр гараад, голын тавцан дээр зогсоод Монголоор овоглож, Монголынхоо төрийн дууллыг эгшиглүүлэх байдаг. Эх орон хүнд ганц л олддоно шүү дээ. Тиймээс гадагшаа явахгүй" хэмээн ярьсан юм.

Улаанбаатарт:

Маргааш  
Өдөр -14  
Шөнө -24

Нөгөөдөр  
Өдөр -13  
Шөнө -22

Өдрийн зурхай

ӨВЛИЙН ЭХЭН ШАРАГЧИН ГАХАЙ САРДӨРВӨН НОГООН МЭНГЭТЭЙ ШАРАГЧИН ТАХИА ӨДӨР

Аргын тооллын: 2016.11.23,

Лхагва гараг

Наран ургах шингэх:

08.10-17.07

Үс засуулбал: Нүд бүрэлзэн улцайна



Тухайн өдөр гахай, хулгана, үхэр, луу, нохой жилтнээ аливаа үйлийг хийхэд эерэг сайн ба могой, морь жилтнээ сөрөг туу нөлөөтэй тул элдэв үйлд хяналгай хандаж, биеэ энхрийлүүштэй. Эл өдөр андгай тангаргаас няцах, дайсныг нотлуулах үйлд сайн. /туу найз нохроос холдож салахад ээлтэй өдөр/ Эм засал хийлгэх, авиши авах, бэрийн үйл, дайсныг дарахад болон хуран чуулах, үс угаахад сайн. Зүүн нүд татвал хувцас олох, баруун нүд татвал тэтгэл болох, баруун чих хангинавал сайн, зүүн нь хангинавал өчүүхэн нэгнийг үзэх, тагнай загатнах, бие татвал үзэсгэлэн болох, хөлийн шөрлөс татвал үг, асуулт болох болой. Өдрийн сайн цаг нь хулгана, бар, туулай, морь, хонь, тахиа болой.

ДУУЛГАХ СОНИН

### Токиогийн их дуулгаг

**Г.БОЛДБААТАР, М.УРАНЦЭЦЭГ, Д.СУМЬЯА** тэргүүтэй 13 жүдоч

оролцоно

Японы нийслэл Токио хотноо ирэх сарын 2-нд жүдо бөхийн "Их дуулга" ангиллын тэмцээн эхлэх учиртай. Тэгвэл одоогоор тус тэмцээнд оролцохоор дэлхийн 46 орны эрэгтэй 201, эмэгтэй 145, нийт 346 жүдоч мэдүүлгээ өгөөд байгаа ажээ. Тэгвэл манайхаас эрэгтэй 9, эмэгтэй 4, нийт 13 тамирчин барилдахаар мэдүүлгээ өгсөн талаар Олон улсын жүдо бөхийн холбооны албан ёсны сайтад мэдээлсэн байна. Эрэгтэйчүүдээс 60 кг-ын жинд Дэлхийн аварга Г.Болдбаатар, дэлхийн аваргын мөнгөн медальт Д.Амартүвшин нар барилдана.

Харин 66 кг-д Г.Хэрлэн, Д.Алтансүх нар барилдахаар

болжээ. Тэгвэл 73 кг-ын жинд залуу тамирчин Б.Баяндүүрэн болон Б.Батцэцэг нар барилдах юм байна. 81 кг-д дэлхийн чансааны 7 дугаарт эрэмбэлэгдэж буй Н.Дагвасүрэн зодоглох бол -100-д Д.Ишдорж, О.Хангай нар барилдах юм байна. Эмэгтэйчүүдийн хувьд 48 кг-д Дэлхийн аварга М.Уранцэцэг зодоглох бол 57 кг-д Олимпын хүрэл медальт Д.Сумьяа барилдахаар болжээ. Тэрбээр Олимпын наадмаас хойш анхны тэмцээндээ оролцох гэж байгаа нь энэ. Тэгвэл 63 кг-ын жинд М.Даваасүрэн барилдах бол 70 кг-д залуу тамирчин М.Баяртуул зодоглохоор мэдүүлгээ өгөөд байгаа ажээ.

### Криштиано Роналдо: Би хөлбөмбөгч Зиданаас дасгалжуулагч Зиданыг илүү дэмжиж байгаа

Испанийн алдарт "Реал Мадрид" клубын довтлогч Криштиано Роналдо багийн дасгалжуулагч Зинедин Зиданы талаар ярьжээ. Тэрбээр "Би Зидантай гайхалтай харилцаатай байдаг. Зиданыг хөлбөмбөгч байхад би хөгжөөн дэмжигч нь байлаа. Одоо дасгалжуулагч Зиданы бүр том фанат болсон. Тэр маш сайн, мөн цаашид дасгалжуулагчийн ажилдаа ч илүү их суралцах байх" хэмээн ярьсан байна.

ТӨСӨӨЛЛӨӨС ИЛҮҮГ ТЭНГИСЭЭС...

## ХЯМДРАЛ, УРАМШУУЛАЛ

Даваа Мянгар Лхагва Пүрэв Баасан Бямба Ням

**ЭХНИЙ ҮЗВЭР БҮР ХЯДРАЛТАЙ: Том хүн - 5000Т, Хүүхэд - 4000Т**

Хосуудын өлөр	Оюутаны өлөр	Ахмадын өлөр
Хосоороо ирсэн хүн бүрт тасалбар	Өдрийн дурш оюутануудад тасалбар	10:00-17:00 Цагийн хооронд тасалбар
5000Т	5000Т	4000Т

### ТӨРСӨН ӨДРИЙН УРАМШУУЛАЛ

Тасалбараа авлааг → Ундаа Попкорн → Үнэмлэгч

**HAPPY BIRTHDAY**